

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН САРЫН МЭДЭЭ

2024 оны 01 дүгээр сар

АГУУЛГА:

1. ДНБ
2. Гадаад худалдаа
3. Түүхий эдийн үнийн хандлага
4. УУ-н бүтээгдэхүүний биржийн арилжаа
5. Төлбөрийн тэнцэл, валютын нөөц
6. Инфляц
7. Төсөв
8. Мөнгө, санхүү
9. Хөдөлмөр
10. Гадаад эдийн засаг – БНХАУ, ОХУ



ЭДИЙН ЗАСГИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

ДНБ-ий өсөлт

(2023 он)

7.0 хувь

Валютын нөөц

(2024 оны 1 дүгээр сар)

4.8 тэрбум \$

Инфляц

(2024 оны 1 дүгээр сар)

7.6 хувь

Төсвийн тэнцэл

(2024 оны 1 дүгээр сар)

676 тэрбум ₮

Экспорт

(2024 оны 1 дүгээр сар)

1,324 сая \$

Импорт

(2024 оны 1 дүгээр сар)

935 сая \$

ГШХО

(2023 оны эхний 3 улирал)

1.9 тэрбум \$

Зээлийн хүү

(2023 оны 12 сар)

16.7 хувь

Ажилчдын тоо

(2023 оны 4 дүгээр улирал)

1.2 сая

*IV улирлын байдлаар ажиллах хүчний оралцооны түвшин 58 хувь байна.

Бодит цалингийн өсөлт

(2023 оны 3 дугаар улирал)

15.2 хувь

Үйл ажиллагаа явуулж буй ААНБ

(2023 оны эцэс)

96.8 мянга

*Худалдаа, үйлчилгээ, барилга, боловсруулах үйлдвэрлэлийн салбарууд давамгайлж байна.

Өрхийн бодит орлогын өсөлт

(2023 оны 4 дүгээр улирал)


14.1 хувь



Эдийн засаг 2023 онд тогтворжиж, 7.0 хувиар өслөө. Уул уурхай, тээврийн салбар эдийн засгийн өсөлтийн дийлэнхийг бүрдүүлсэн бол хөдөө аж ахуйн салбар агшиж, өсөлтийг хязгаарлалаа. Хөдөө аж ахуйгаас бусад бүх салбарын үйлдвэрлэл өссөн.

ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ

(хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Нэрлэсэн ДНБ 2023 онд 68.9 их наяд төгрөгт хүрч, 27.9 хувиар, бодит ДНБ 30.5 их наяд төгрөгт хүрч, **7.0 хувиар тус тус өслөө.**
- Анхдагч салбар: Уул уурхайн салбар 23 хувиар тэлж, ХАА-н салбар 8.9 хувиар агшив.
- Хоёрдогч салбар /боловсруулах, барилга, цахилгаан, усан хангамж/-ын үйлдвэрлэл 4.1 хувиар өссөн байна.
- Үйлчилгээний салбар /худалдаа, тээвэр, үйлчилгээний бусад/ 9.2 хувиар өслөө.
- Бүтээгдэхүүний цэвэр татвар 6.8 хувиар өссөн байна.

ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ

(2023 он)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Уул уурхай, тээврийн салбар гадаад валютын нөөц, экспортыг нэмэгдүүлэх арга хэмжээний үр дүнд тус тус 23 болон 39 хувиар өсөж, өсөлтийн 4.4 нэгж хувийг бүрдүүллээ.
- Худалдаа, үйлчилгээний салбаруудын идэвхжил нэмэгдэж, тус салбарууд өсөлтийн 2.5 нэгж хувийг бүрдүүлэв.
- Харин өвөлжилт хүндэрсний улмаас малын тоо толгой буурч, хөдөө аж ахуйн салбар 8.9 хувиар агшиж, өсөлтийг хязгаарлалаа.

УУЛ УУРХАЙ, ТЭЭВРИЙН САЛБАР

(өсөлтийн хувь)




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Уул уурхай болон тээврийн салбарын өсөлт 2023 онд хамгийн өндөр түвшинд хүрлээ.
- Нүүрсний олборлолт 2023 онд түүхэн дээд хэмжээнд хүрч, газрын тос, зэсийн баяжмал зэрэг уул уурхайн бүтээгдэхүүний үйлдвэрлэл нэмэгдсэнээр тус салбарын үйлдвэрлэл идэвхэжлээ.
- Бүх төрлийн тээврээр 2023 онд 102 сая тонн ачаа тээвэрлэж, уул уурхайн бүтээгдэхүүний тээвэр зохион байгуулалт сайжирсан нь тээврийн салбар сэргэхэд нөлөөлөв.

ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАР

(өсөлтийн хувь)




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- ХАА-н салбар **8.9 хувиар** буурлаа.
- Малын тоо толгой өмнөх оноос 6.4 сая толгой малаар (9.1 хувь) буурч 2023 оны жилийн эцэст 64.7 сая толгой мал тоологдлоо. Энэ нь 2016-2017 оны малын тоо толгойн түвшинтэй ойролцоо юм.
- Том малын зүй бус хорогдол 4.9 сая толгойд хүрч 2010 оны түүхэн дээд хэмжээний дараа орлоо. Нийт хорогдсон малын 86 хувийг хонь, ямаа эзэлж байгаа ба 69 хувийг манай улсын нийт малын 44 хувийг бүрдүүлдэг 7 аймаг бүрдүүлж байна. (Хэнтий, Архангай, Сүхбаатар, Увс, Ховд, Хөвсгөл, Булган)



Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл 2024 оны 1 дүгээр сард өмнөх онтой харьцуулахад 22 хувиар нэмэгдээд байна. Уул уурхайн салбарын үйлдвэрлэл гол нөлөөг үзүүлсэн хэвээр байна.

НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ (тэрбум төгрөг)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

БОДИТ ҮЙЛДВЭРЛЭЛ (өсөлтийн хувь)




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, тооцоолол

УУЛ УУРХАЙН ҮЙЛДВЭРЛЭЛ (голлох бүтээгдэхүүнээр)

Төрөл	Өмнөх оноос өөрчлөлт
Нүүрс	6.9 сая тонн / 12%
Зэсийн баяжмал	119 мян.тонн / -1%
Газрын тос	0.4 сая баррель / -15%
Алт	0.7 тонн / 40%
Төмрийн хүдэр	345 мянган тонн / 2%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ҮЙЛДВЭРЛЭГЧИЙН ҮНИЙН ИНДЕКС (2015=100)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл 2024 оны 1 дүгээр сард 1.8 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 22 хувиар өслөө.
- Нүүрс, алт, төмрийн хүдэр зэрэг бүтээгдэхүүний үйлдвэрлэл нэмэгдэж, уул уурхайн салбарын үйлдвэрлэл 25 хувиар нэмэгдээд байна.

- Аж үйлдвэрийн салбарын бодит үйлдвэрлэл 2024 оны 1 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 13.6 хувиар өсөөд байна. Үүнээс, уул уурхайн салбар 21.0 хувиар, боловсруулах салбар 8.6 хувиар өслөө.

- Нүүрс олборлолт 2024 оны 1 дүгээр сард 6.9 сая тоннд хүрч өмнөх оны мөн үеэс 12 хувиар нэмэгдлээ.
- Алтны олборлолт өмнөх оны 1 дүгээр сараас 40 хувиар нэмэгдсэнээр 0.7 тоннд хүрэв.
- Төмрийн хүдэр, баяжмал олборлолт өмнөх оны мөн үеэс 2 хувиар нэмэгдээд байна.
- Харин газрын тос олборлолт өмнөх оны мөн үеийн үйлдвэрлэлийн түвшинг даваагүй байна.


- Үйлдвэрлэгчийн үнийн индекс өмнөх оны мөн үеэс 4 хувь, цар тахлын өмнөх үеэс 69 хувиар тус тус өслөө. Үнийн индексийг салбараар харвал:
- Уул уурхайн үйлдвэрлэл 2.2 хувиар,
- Хүнсний бүтээгдэхүүн 17 хувиар,
- Ундаа, согтууруулах ундаа 10 хувиар,
- Нэхмэлийн үйлдвэрлэлийнх 9 хувиар тус тус өсөж
- Арьс, арьсан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийнх 0.4 хувиар буурлаа.



Гадаад, дотоод эрэлт эерэг төлөвтэй байж, эдийн засаг өсөлтөө хадгаллаа.


ДНБ ӨСӨЛТИЙН БҮТЭЦ

(жилийн өсөлтийн хувь)



ЭЦСИЙН ХЭРЭГЛЭЭНИЙ БҮТЭЦ

(жилийн өсөлтийн хувь)




ХӨРӨНГИЙН ХУРИМТЛАЛЫН БҮТЭЦ

(жилийн өсөлтийн хувь)



ЭКСПОРТ, ИМПОРТЫН ӨСӨЛТ

(жилийн өсөлтийн хувь)



- Эрэлтээс тооцсон ДНБ 2023 оны урьдчилсан гүйцэтгэлээр 7.1 хувиар өслөө.
- Өсөлтөд эцсийн хэрэглээ 6.1 нэгж хувийн, цэвэр экспорт 5.2 нэгж хувийн тус тус эерэг нөлөө, хөрөнгийн хуримтлал -4.3 нэгж хувийн сөрөг нөлөө үзүүллээ.

- Эцсийн хэрэглээ 2023 онд 25.9 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 7.2 хувиар өсөв.
- Эцсийн хэрэглээний өсөлтийн 5.7 нэгж хувийг өрхийн хэрэглээ, 1.6 нэгж хувийг төрийн хэрэглээ бүрдүүлж байна.

- Үндсэн хөрөнгийн хуримтлал 7.0 хувиар өслөө.
- Үндсэн хөрөнгийн хуримтлалын өсөлтөд орон сууцны бус барилга байгууламж 6.4 нэгж хувийн, машин тоног төхөөрөмж 2.7 нэгж хувийн, орон сууцны барилга 0.6 нэгж хувийн нэмэгдүүлэх нөлөөг тус тус үзүүлсэн бол том малын хорогдол 2.4 нэгж хувийн бууруулах нөлөө үзүүллээ.


- Бараа, үйлчилгээний экспорт 2023 онд импортоос 2 дахин хурдтай нэмэгдлээ.
- Бараа, үйлчилгээний цэвэр экспорт -7.5 их наяд төгрөг болж, өмнөх оноос 16.6 хувиар буурав.



2024 эхний 1 дүгээр сарын байдлаар гадаад худалдааны тэнцэл 389 тэрбум ам.долларын ашигтай гарч, өмнөх оны мөн үеэс 1 хувиар буурлаа.

ЭКСПОРТ


(сая ам доллар)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

ГОЛЛОХ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЭКСПОРТ


(сая ам доллар)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

ИМПОРТ

(сая ам доллар)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

ГОЛЛОХ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ИМПОРТ

(сая ам доллар)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

- 2024 оны 1 дүгээр сарын байдлаар экспорт 1,325 сая ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 19 хувиар өссөн байна.
- Нийт экспортын 94 хувийг уул уурхай бүтээгдэхүүн, тэр дундаа нүүрсний экспорт дангаараа 61 хувийг бүрдүүлж байна.

- Нүүрсний экспортын орлого 803 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 29 хувиар өслөө.
- Зэсийн баямжлын экспортын орлого 220 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 16 хувиар өслөө.
- Газрын тосны экспортын орлого 27 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 7 хувиар буурлаа.
- Төмрийн хүдрийн экспортын орлого 47 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 45 хувиар өслөө.

- 2024 оны 1 дүгээр сарын байдлаар импорт 936 сая ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 26 хувиар өссөн байна.
- Нийт импортын 21 хувийг нефт, 18 хувийг автомашин эзэлж байна.


- Тонго төхөөрөмжийн импорт 258 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 32 хувиар өслөө.
- Суудлын автомашины импорт 132 сая ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 49 хувиар өслөө.



2024 эхний 1 дүгээр сарын байдлаар уул уурхайн бүтээгдэхүүн нийт экспортын 94 хувийг, тэр дундаа нүүрс, зэсийн баяжмал дангаараа 77 хувийг бүрдүүллээ.

НҮҮРС


(сая тонн)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

ЗЭСИЙН БАЯМЖАЛ


(тонн)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

ТӨМРИЙН ХҮДЭР


(мян тонн)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

ГАЗРЫН ТОС

(мян баррель,)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

- Нүүрсний экспорт 2024 оны эхний 1 сард 6.8 сая тоннд хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 1.9 дахин өслөө.
- Гашуунсухайт боомтоор 3.6 сая тонн, Шивээхүрэн боомтоор 1.8 сая тонн, Ханги боомтоор 0.6 сая тонн, бусад боомтуудаар 0.7 сая тонн нүүрс экспортолсон байна.

- Зэсийн баяжмалын экспорт 2024 оны эхний 1 сард 124 мянган тоннд хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 11 хувиар өслөө.
- Гашуунсухайт боомтоор 73 мянган тонн, Зам-үүд боомтоор 51 мянган тонн зэсийн баяжмал экспортолсон байна.

- Төмрийн хүдрийн экспорт 2024 оны эхний 1 сард 596 мянган тоннд хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 40 хувиар өслөө.
- Зам-үүд боомтоор 525 мянган тонн, Бургастай боомтоор 63 мянган тонн, бусад боомтуудаар 8 мянган тонн төмрийн хүдэр экспортолсон байна.


- Газрын тосны экспорт 2024 оны эхний 1 сард 357 мянган баррельд хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 6 хувиар буурлаа.
- Баянхошуу боомтоор 340 мянган баррель, Замын-үүд боомтоор 17 мянган баррель газрын тос тус тус экспортолсон байна.



2024 эхний 1 дүгээр сарын ноолуураас бусад голлох хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний экспорт өмнөх оны мөн үеэс буурлаа.

МАЛЫН МАХ


(сая тонн)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

БОЛОВСРУУЛСАН АРЬС ШИР


(метр квадрат)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

НООЛУУР


(тонн)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

НООС

(тонн)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар


- Малын махны экспорт 2024 оны эхний 1 сард 6,760 мянган тоннд хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 25 хувиар буурлаа.
- Тэр дундаа боловсруулсан махны экспорт өмнөх оны мөн үеэс 2 дахин багасаж 2,667 мянган тоннд хүрлээ.
- Боловсруулсан арьс ширний экспорт 2024 оны эхний 1 сард 2,793 метр квадратад хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 2 дахин буурлаа.
- Ноолуурын экспорт 2024 оны эхний 1 сард 131 тоннд хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 2.4 дахин өслөө.
- Ноосны экспорт 2024 оны эхний 1 сард 705 тоннд хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 4 дахин буурлаа.



ДЭЛХИЙН ЗАХ ЗЭЭЛ ДЭЭРХ ТҮҮХИЙ ЭДИЙН ҮНИЙН ХАНДЛАГА

НҮҮРС


(\$/тонн, Сингапурын бирж дэх Австралийн сайн чанарын коксжих нүүрс)



Эх сурвалж: Блүүмберг

ЗЭС


(\$/тонн, Лондоны металлын бирж дэх цэвэр эс)



Эх сурвалж: Блүүмберг

ТӨМРИЙН БАЯЖМАЛ


(\$/тонн, Зүүнхойд Хятад дахь 62 хувийн агууламттай төмрийн баяжмал)



Эх сурвалж: Блүүмберг

ГАЗРЫН ТОС

(\$/баррель, Brent)



Эх сурвалж: Блүүмберг

- Сингапурын бирж (SGX) дэх Австралийн сайн чанарын коксжих нүүрсний 2024 оны эхний 1 сарын дундаж үнэ 332 ам.долларт хүрч, өмнөх оны эцсээс 7 хувиар өссөн байна.
- Олон улсын шинжээчдийн таамаглалаар 2024 оны дундаж үнэ 250 ам.доллар, 2025 онд 210 ам.долларт хүрэхээр байна.

- Лондоны металлын бирж (LME) дэх цэвэр зэсийн үнэ 2024 оны эхний 1 сарын дундаж 8,350 ам.доллар болж, өмнөх оноос 1 хувиар өссөн байна.
- Олон улсын шинжээчдийн таамаглалаар 2024 оны дундаж үнэ 8,500 ам.доллар, 2025 онд 9,000 ам.долларт хүрэхээр байна.


- Зүүн хойд Хятад дахь төмрийн баяжмалын 2024 оны эхний 1 сарын дундаж үнэ 136 ам.доллар болж, өмнөх оны эцсээс 10 хувиар буурсан байна.
- Олон улсын шинжээчдийн таамаглалаар төмрийн баяжмалын дундаж үнэ 2024 онд 110 ам.доллар, 2025 онд 100 ам.долларт хүрэхээр байна.

- Бrent газрын тосны 2024 оны эхний 1 сарын дундаж үнэ 79 ам.долларт хүрч өмнөх оны эцсээс 1 хувиар өслөө.
- Олон улсын шинжээчдийн таамаглалаар 2024 оны дундаж үнэ 80 ам.доллар, 2025 оны дундаж үнэ 80 ам.долларт хүрэхээр байна.




МОНГОЛ УЛСЫН ХИЛИЙН ҮНИЙН ХАНДЛАГА

НҮҮРС (\$/тонн, Хил үнэ)




Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

ЗЭСИЙН БАЯЖМАЛ (\$/тонн, Хил үнэ)




Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

ТӨМРИЙН БАЯЖМАЛ (\$/тонн, Хил үнэ)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

ГАЗРЫН ТОС (\$/баррель, Хил үнэ)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

- Чулуун нүүрсний 2024 оны эхний 1 сарын хилийн дундаж үнэ 122 ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 31 хувиар буурсан байна.

- Зэсийн баяжмалын хилийн үнэ 2024 оны эхний 1 сарын дунджаар 1,774 ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 6 хувиар өссөн байна.

- Төмрийн хүдрийн 2023 оны дундаж үнэ 80 ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 10 хувиар өссөн байна.


- Газрын тосны 2023 оны дундаж үнэ 76 ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 2 хувиар буурсан байна.



2024 оны 2 дугаар 19-ны өдрийн байдлаар УУББ-ээр 9 төрлийн, нийт 18.6 сая тонн нүүрс, 894 мянган тонн төмрийн хүдэр, баяжмалыг арилжаалаад байна.

НҮҮРСНИЙ АРИЛЖАА


(сая тонн)



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

НҮҮРСНИЙ ДУНДАЖ ҮНЭ


(ам.доллар/тонн)



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

ТӨМРИЙН АРИЛЖАА


(мянган тонн)



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

ТӨМРИЙН ДУНДАЖ ҮНЭ

(ам.доллар/тонн)



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

- 2024 оны 2 дугаар сарын 19-ны өдрийн байдлаар нийт 18.6 сая тонн нүүрс арилжиж, 2.6 тэрбум ам.долларын орлого олжээ.
- 2024 оны 2 дугаар сарын 19-ны байдлаар 2024 онд 3.7 сая тонн нүүрс арилжиж, 498 сая ам.долларын орлого олжээ.
- Он гарснаар нүүрсний арилжааны тоо хэмжээ буурч 1 дүгээр сарын эцсийн байдлаар 1.5 сая тонн нүүрс борлуулж, өмнөх сараас 56 хувиар буурлаа.

- Нүүрсний 2 дугаар сарын дуудах дундаж үнэ 150 ам.доллар, хэлцлийн дундаж үнэ 171 ам.доллар байв.
- Нүүрсний төрлөөс хамааран 2 дугаар сард хэлцлийн доод үнэ 79 ам.доллар, дээд үнэ 206 ам.долларт хүрсэн ба дундаж үнэ 176 ам.доллар байна.

- 2023 оны 9 дүгээр сараас хойш 2023 онд нийт 677.5 мянган тонн төмрийн хүдэр, баяжмалыг 196 тэрбум төгрөг буюу 57 сая ам.долларын борлууллаа.
- Он гарснаар 1 дүгээр сард 102 мянган тонн төмөр борлуулж, өмнөх сараас 19 хувиар буурлаа.
- 2024 оны 2 дугаар сарын 19-ны өдрийн байдлаар 894 мянган тонн төмрийг арилжаалж, 74 сая ам.долларын орлого олжээ.
- 2024 оны 2 дугаар сарын 6-ны өдрөөс эхлэн “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК биржээр төмрийн хүдэр арилжаалж эхэлсэн.

- Төмрийн хүдэр болон баяжмалын 2 дугаар сарын дуудах дундаж үнэ 76 ам.доллар, хэлцлийн дундаж үнэ 79 ам.доллар байв.
- Төмрийн төрлөөс хамааран 2 дугаар сард хэлцлийн доод үнэ 56 ам.доллар, дээд үнэ 105 ам.долларт хүрсэн ба дундаж үнэ 176 ам.доллар байна.



Засгийн газраас авч хэрэгжүүлж буй гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээний үр дүнд уул уурхайн экспортын орлого нэмэгдэж, төлбөрийн тэнцэл 2023 оны эцэст өмнөх оноос 2.2 тэрбум ам.доллараар сайжирч, 1.5 тэрбум ам.доллартай ашигтай гарлаа. Гадаад валютын улсын нөөц 2024 оны 1 дүгээр сард өмнөх сараас буурсан ч төгрөгийн ханш чангарсан хэвээр байна.



- Төлбөрийн тэнцэл 2023 оны эцэст 1,457 сая ам.доллартай ашигтай гарч, өмнөх оноос 2.2 тэрбум ам.доллараар сайжирлаа.
- Бараа, үйлчилгээний экспорт өмнөх оноос 4.4 тэрбум ам.доллараар нэмэгдэж, урсгал дансны ашиг 2007 оноос хойш анх удаа оны эцэст ашигтай гарлаа.
- Төлбөрийн тэнцлийн шууд хөрөнгө оруулалтын цэвэр орох урсгал* 2023 онд 1,767 сая ам.доллар болж, өмнөх оноос 737 сая ам.доллараар буурсан байна.

- Гадаад валютын улсын нөөц 2024 оны 1 дүгээр сарын эцэст 4,849 сая ам.доллар болж, өмнөх сарын эцсээс 72 сая ам.доллараар буурав.

- 2024 оны 1 дүгээр сард төгрөгийн ам.доллартой харьцах ханш өдөрт дунджаар 0.4 төгрөгөөр чангарлаа.
- Улмаар 2024 оны 1 дүгээр сарын эцэст төгрөгийн ам.доллартой харьцах ханш 3,401 болж, оны эхнээс 9 төгрөгөөр буюу 0.3 хувиар чангарлаа.

- Төв банк 2024 оны 1 дүгээр сард нийт 540 сая ам.долларыг банкуудад дуудлага худалдаагаар худалдлаа.
- Энэ нь 2023 оны мөн үеэс 205 сая ам.доллар буюу 61 хувиар их, 2022 оны мөн үеэс 26 сая ам.доллар буюу 5 хувиар бага дүн байв.


*Нийт хөрөнгө оруулалтаас хөрөнгө оруулалтын буцаалт болон эзэлийн эргэн төлөлттэй холбоотой гарах урсгалыг хассан дүн



Инфляц 2024 оны 1 дүгээр сард 7.6 хувь гарч, төв банкны зорилтот түвшинд хадгалагдаж байна. Дотоодын бараа, үйлчилгээний инфляц сүүлийн 4 сар саарч байгаа боловч нийт инфляцад эзлэх нэгж хувь өндөр хэвээр байна. Нийт бараа, үйлчилгээний үнэ өмнөх сараас 0.8 хувиар өсжээ.

ЖИЛИЙН ИНФЛЯЦ


(хувь)



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

САРЫН ИНФЛЯЦ


(хувь)



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

СУУРЬ ИНФЛЯЦ


(хувь)



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

ГОЛЛОХ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ИНФЛЯЦ

(хувь)



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

- Инфляц 2024 оны 1 дүгээр сард улсын хэмжээнд 7.6 хувьд хүрч, төв банкны зорилтот түвшинд хадгалагдаж байна.
- Импортын гаралтай инфляц нийт инфляцын 2.6 нэгж хувь (34.2%)-ийг бүрдүүлж байна.
- Дотоодын бараа, үйлчилгээний үнийн өсөлт нийт инфляцын 5 нэгж хувь буюу 65.8 хувийг эзэлж байна.

- 2024 оны 1 дүгээр сард нийт бараа, үйлчилгээний үнэ өмнөх сараас 0.8 хувиар өсөв.
- Нийт бараа, үйлчилгээний үнэ өмнөх сараас өсөхөд хүнсний бүлэг 63 хувиар нөлөөлжээ.
- Сарын инфляцад мах, махан бүтээгдэхүүн 37%, сүү 10%, талх, гурил, будаа 7%-ийг тус тус бүрдүүлж байна.

- Суурь инфляц нь нийт инфляцаас хүнс, шатахуун, хатуу түлшний үнийг хасаж тооцсон эрэлтийн гаралтай инфляц юм.
- 2024 оны 1 дүгээр сард суурь инфляц 6.3 хувь гарч, нийт инфляцын 4.2 нэгж хувийг бүрдүүлж байна.
- Сүүлийн хагас жил суурь инфляц алгуур буурч инфляцын зорилтот түвшинд ороод байна.


- Мах, сүү, гурил зэрэг голлох бүтээгдэхүүнүүдийн үнийн өсөлт 2024 оны 1 дүгээр сард жилийн инфляцын 21 орчим хувийг бүрдүүлж байна.
- Гурил, гурилан бүтээгдэхүүний үнэ өмнөх оны мөн үеэс 18.6 хувиар өсжээ.
- Сүү, сүүн бүтээгдэхүүн, өндөгний үнэ өмнөх оны мөн үеэс 15.6 хувиар өсөв.
- Хонины махны үнэ өмнөх оны мөн үеэс 18.4 хувиар өслөө.



Монгол Улсын нэгдсэн төсөв 2024 оны 1 дүгээр сарын байдлаар 676 тэрбум төгрөгийн ашигтай гарлаа. Орлого нэмэгдэхэд уул уурхайн салбараас орж ирэх АМНАТ-ын орлого өссөн нь голлон нөлөөллөө.

ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ТЭНЦЭЛ


(их наяд төгрөг)



Эх сурвалж: Сангийн яам

ТӨСВИЙН ОРЛОГО


(орлогын эх үүсвэрээр, их наяд төгрөг)



Эх сурвалж: Сангийн яам

2023 онд нэмэгдсэн голлох ЗАРЛАГУУД


(зарлагын эх үүсвэрээр, их наяд төгрөг)



Эх сурвалж: Сангийн яам

ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР (ӨҮЦ)

(их наяд төгрөг, ДНБ-д эзлэх хувь)



Эх сурвалж: Сангийн яам

- Нэгдсэн төсөв 2024 оны 1 дүгээр сард 676 тэрбум төгрөгийн ашигтай гарч, өнгөрсөн оны мөн үеэс 708 тэрбум төгрөгөөр өссөн байна.

- Орлого 2024 оны 1 дүгээр сард 2.8 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 1.5 их наяд төгрөг буюу 117 хувиар нэмэгдсэн байна.
- Дээрх өсөлтөд орлогын албан татвар 544 тэрбум төгрөг, АМНАТ 553 тэрбум төгрөг, НӨАТ 147 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн нь голчлон нөлөөллөө.

- Зарлага 2024 оны 1 дүгээр сард 2.1 их наяд төгрөгт хүрч өнгөрсөн оноос 935 тэрбум төгрөг буюу 84 хувиар нэмэгдсэн байна.
- 2024 онд төрийн бүх албан хаагчдын цалинг 10 хувиар, нийтлэг үйлчилгээний ажиллагсдын цалинг 20 хувиар нэмэгдүүлэхээр төлөвлөсөн.

- Засгийн газрын өр 2023 оны урьдчилсан гүйцэтгэлээр 30.8 их наяд төгрөгт хүрч, өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн үлдэгдлийг ДНБ-д харьцуулсан харьцаа 43.7 хувьд хүрээд байна.
- 2023 оны урьдчилсан гүйцэтгэлээр Засгийн газрын өр (ӨҮЦ)-ийн үлдэгдлийг ДНБ-д харьцуулсан харьцаа хуульд заасан тусгай шаардлагыг хангаж байна.



Мөнгөний нийлүүлэлт 2023 оны эцэст 37.6 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 26.8 хувиар өссөн байна. Үүнд төгрөгийн хадгаламж 36 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

МӨНГӨНИЙ НИЙЛҮҮЛЭЛТ

(их наяд төгрөг)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Мөнгөний нийлүүлэлт 2023 оны эцэст 37.6 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 26.8 хувиар өссөн байна. Үүнд, төгрөгийн хадгаламж 36 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

ХАДГАЛАМЖИЙН ҮЗҮҮЛЭЛТ

(их наяд төгрөг)




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Нийт хадгаламж 22.1 их наяд төгрөгт хүрч хүрч өмнөх оны мөн үеэс 26.2 хувиар өслөө.
- Төгрөгийн хадгаламж 17.1 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 36 хувиар, өмнөх сараас 7.6 хувиар өсөв.
- Гадаад валютын хадгаламж 5.0 их наяд төгрөгтэй тэнцэх хэмжээнд хүрч өмнөх оны мөн үеэс 1.8 хувиар, өмнөх сараас 2.9 хувиар өсөв.

ЗЭЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ

(их наяд төгрөг)




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Банкнуудын зээлийн үлдэгдэл 2023 оны 12 дугаар сард 27.4 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 24 хувиар өсөв.
- Чанаргүй зээлийн үлдэгдэл 2.0 их наяд төгрөг байна. Чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь 7.4 хувь буюу өнгөрсөн оноос 1.7 нэгж хувиар буурсан байна.

ХҮҮГИЙН ТҮВШИН

(жигнэсэн дундаж хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Банкнуудын зээлийн жигнэсэн дундаж хүү 2023 оны 12 дугаар сард 16.7 хувь болж өмнөх оноос 1.0 нэгжээр өсөв.
- Банкнуудын хадгаламжийн жигнэсэн дундаж хүү 2023 оны 12 дугаар сард 11.6 хувь болж өмнөх оноос 0.7 нэгжээр өсөв.



Эдийн засаг сүүлийн зургаан улирал дараалан эерэг өсөлттэй байгаа ч хөдөлмөрийн зах зээлийн үзүүлэлт цар тахлын өмнөх түвшнээс бага хэвээр байна. Мөн сүүлийн 5 улирал дараалан ажиллах хүч буурч, ажиллах хүчнээс гадуурх хүн ам тэлсэн байна.

АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН (хувь)




- Ажиллах хүчний оролцооны түвшин 57.6 хувь болж буурсан ба цар тахлын өмнөх үеэс 2.5 хувиар доогуур байна.
- Ажилгүй иргэдийн тоо 2023 оны 4 дүгээр улиралд өмнөх оны мөн үеэс 15.8 мянган хүнээр буурч, 48.8 мянгад хүрлээ.
- Ажилгүйдлийн түвшин өмнөх оны мөн үеэс 1.4 хувиар буурч, 3.9 хувьд хүрлээ.

АЖИЛЧДЫН ТООНЫ ӨӨРЧЛӨЛТ (мянган хүн)




- Ажилчдын тоо 2023 оны 4 дүгээр улирлын байдлаар 1.2 саяд хүрч өмнөх оны мөн үетэй харьцуулахад 40 мянган хүнээр нэмэгдсэн ч өсөлтийн хурд бага байна.
- Ажилчдын тооны өсөлтөд, худалдаа, барилга, боловсруулах, тээвэр, үйлчилгээ ба бусад, уул уурхай, ус, цахилгааны салбарын ажилчид эергээр нөлөөлсөн.
- Харин хөдөө аж ахуйн салбарын ажилчид сөргөөр нөлөөллөө.

ДУНДАЖ ЦАЛИНГИЙН ӨӨРЧЛӨЛТ (хувь)



- Дундаж цалингийн хэмжээ 2023 оны 3 дугаар улирлын байдлаар өмнөх оны мөн үеэс 27.3 хувиар өсөж, 2,009 мянган төгрөгт хүрлээ.
- Салбараар авч үзвэл, уул уурхайн салбарын дундаж цалин бусад салбараа тэргүүлж, улсын дунджаас 2.4 дахин өндөр байна.

БҮРТГЭЛТЭЙ ААНБ-ЫН ТОО (мянга, үйл ажиллагаа явуулж байгаа)




- Нийт бүртгэлтэй ААНБ-ын тоо өмнөх онтой харьцуулахад буурсан. Үүнд, үйл ажиллагаа явуулаагүй ААНБ буурсан нь голлон нөлөөлжээ.
- Үйл ажиллагаа явуулж байгаа ААНБ-ын тоо 2023 онд 96.8 мянгад хүрч өмнөх оноос 5 мянгаар нэмэгдлээ.
- Уг өсөлтөд худалдаа, үйлчилгээний салбарын жижиг бизнесүүд /1-9 ажилтантай ААН/ийн тоо нэмэгдсэн нь голлох нөлөөг үзүүлсэн байна.



2023 онд БНХАУ-ын гадаад, дотоод эрэлт буурч, экспорт 2016 оноос хойш, импорт цар тахлаас хойш анх удаа тус тус агшлаа. Аж үйлдвэрийн салбарын худалдан авалтын менежерийн индекс 2024 оны 1 дүгээр сард өмнөх сараас өссөн хэдий ч босго утга 50-аас бага байгаа нь идэвхжил сул байгааг харуулж байна.


БНХАУ-ын 1 болон 2 дугаар сарын гадаад худалдаа, аж үйлдвэрлэл, жижиглэнгийн худалдааны статистик нэгтгэгдэн 3 дугаар сард зарлагддаг.

ХУДАЛДАН АВАЛТЫН МЕНЕЖЕРИЙН ИНДЕКС (PMI) (нэгж)




- Аж үйлдвэрийн салбарын PMI индекс 2024 оны 1 дүгээр сард 49.2 болж, өмнөх сараас 0.2 нэгжээр өссөн ч сүүлийн 4 сар босго утга 50-аас бага хэвээр байна.
- Аж үйлдвэрийн бус салбарын PMI индекс 50-аас дээш хэвээр байна.

ЭКСПОРТ, ИМПОРТЫН ӨСӨЛТ (хувь, өссөн дүнгээр)



- 2023 оны эцэст экспортын өсөлт - 4.6 хувьд хүрч, 2016 оноос хойш анх удаа агшлаа.
- Импорт 2023 онд өмнөх оноос 5.5 хувиар буурсан нь цар тахлаас хойших анхны агшилт болов.
- Худалдааны эрчим буурсан нь Хятадын гадаад болон дотоод эрэлтийн буурсныг харууллаа.

ИНФЛЯЦ (хувь)



- 2023 оны 1 дүгээр сард 2.1 хувь байсан инфляц 2023 оны эцэст -0.3 хувь болж буурч, 2009 оны 9 дүгээр сараас хойших хамгийн бага түвшинд хүрлээ.

АЖ ҮЙЛДВЭРЛЭЛ, ЖИЖИГЛЭН ХУДАЛДААНЫ ӨСӨЛТ (хувь)




- 2023 онд аж үйлдвэрийн гарц 4.6 хувиар, жижиглэн худалдаа 7.2 хувиар тус тус өсөж, үйлдвэрлэл, хэрэглээний өсөлт нийт эдийн засгийн өсөлтийг голлон дэмжлээ.

Тус индекс нь богино хугацааны идэвхжлийг илэрхийлэх бөгөөд ААН-үүдийн худалдан авалт, үйлдвэрлэл, ажил эрхлэлт, түүхий эдийн нөөц зэрэг үзүүлэлтийн талаарх аж үйлдвэрийн салбарын 3200 судалгаа, аж үйлдвэрийн бус салбарын 4300 судалгаанд үндэслэн сар бүр тооцдог. Индексийн 50-аас дээш утга нь тэлэлтийг, 50-аас доош нь агшилтыг илэрхийлнэ.




ОХУ-ын ДНБ 2023 оны 3 дугаар улиралд өмнөх оны мөн үеэс 5.5 хувиар өссөн бол 2023 оны 4 дүгээр улиралд 4 орчим хувиар өснө гэсэн таамаглалтай байна. Өсөлтийг төсвийн зарлагын тэлэлт, аж үйлдвэрийн өргөжилт, цэрэг армийн зардал дэмжсэн байна.

БОДИТ ДНБ-ИЙ ӨСӨЛТ
(хувь)



- Дотоодын нийт бүтээгдэхүүн 2023 оны 3 дугаар улиралд 5.5 хувиар өслөө.
- Засгийн газрын эцсийн хэрэглээний зардал 2023 оны гуравдугаар улиралд 5.4 хувиар өссөн байна.
- ОХУ-ын цэргийн армийн зардлын өсөлттэй холбоотой төсвийн зардал тэлэлт, бараа бүтээгдэхүүний үнийн өсөлттэй холбоотой эдийн засаг 2021 оны 4 дүгээр улирлаас хойш хамгийн өндөр өсөлт хүрээд байна.

ХУДАЛДААНЫ ТЭНЦЭЛ
(тэрбум ам.доллар)




- Экспорт 2023 оны 3 дугаар улиралд өмнөх оны мөн үеийнхээс 25.1 хувиар, 2021 оны 3 дугаар улирлын дүнгээс 19.7 хувиар буурсан байна.
- Импорт 2023 оны 3 дугаар улиралд 2021 оны 3 дугаар улиралтай харьцуулахад 2.6 хувиар буурчээ.

ИНФЛЯЦ
(хувь)



- 2023 оны 1 дүгээр сард 11.8 хувь байсан инфляц 2024 оны 1 дүгээр сард 7.4 хувь болж буурсан.
- 2024 оны 1 дүгээр сард инфляцын түвшин 7.4 хувь хэвээр байгаа нь Төв банкны зорилтот түвшин 4 хувиас давсан хэвээр байна.

ХУДАЛДАН АВАЛТЫН МЕНЕЖЕРИЙН ИНДЕКС (PMI) (нэгж)



- Аж үйлдвэрийн салбарын PMI индекс 2024 оны 1 дүгээр сард 52.4 болж, өмнөх сараас 2.2 нэгжээр буурсан ч босго утга 50-аас өндөр хэвээр байна.
- 2023 оны 12 дугаар сард аж үйлдвэрийн салбарын PMI сүүлийн 7 жилийн хамгийн дээд түвшин 54.6 хувьд хүрсэн байна.
- Бодит өсөлт 2023 оны 12 дугаар сард өмнөх оны мөн үеэс 4.5 хувь, өмнөх сараас 2.7 хувиар өссөн байна.



ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМ